



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/572

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зарим эмнэлгүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Даваасүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх
Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах
ажиллагааны албаны дарга

Нарийн бичгийн дарга: Т.Гантулга Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон
нутгийн өмчийн газрын ажил худалдан авах
ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: З.Нацагням Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн мэргэжилтэн

В.Ганцэцэг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ахлах ажилтан
Ш.Авирмэд Бүтээлч хөгжлийн хөтөч ТББ-ын гишүүн (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Б.Даваасүрэн)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Т.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101044